

Living the LOTUS

Buddhism in Everyday Life



Үүсгэн байгуулагчийн сургаал

Нигүүлсэнгүй нүдээр хардаг болох

Шагжамүни бурханы амьдарч байсан тухайн үеийн Энэтхэгт Коосала хэмээх том гүрэн байжээ. Тэр улсын хаан нэгэн удаа “Яаж ч толгойгоо гашилтал бодсон өөрөөс минь өөр хайрламаар хүн алга. Та юу гэж бодож байна?” хэмээн гүнжээсээ асуутал, гүнж ч бас бодоод үзэхэд үнэхээр л би өөртөө л хамгийн хайртай юм байна хэмээн хариулжээ.

Тэгээд Шагжамүни бурханаас асууж үзэхээр болов. Тэр хаан болон хааны гүнжид Шагжамүни бурхан бээр: “Өөрийгөө хамгийн их хайрладаг гэдгээ мэдсэн бол бусад хүн ч гэсэн өөртөө хамгийн их хайртай болохыг ойлгох биз ээ. Тиймээс бусдыг хохироож үл

болно.” хэмээн сургажээ.

Бид магадгүй зөвхөн өөрийнхөө байр сууринаас аливаад ханддаг. Тийм үедээ түр өөрийгөө хойш нь тавиад, нөгөө хүнийхээ оронд өөрийгөө тавиад үзээрэй. Нөгөө хүнийхээ оронд бодож үзээрэй. Тэгвэл тухайн зүйл огт өөрөөр харагдах болно. Нүднээс өргөс авсан мэт л нөгөө хүний зүрх сэтгэл, юмсын үнэн дүр төрх харагдах болно.

Бусдын оронд өөрийгөө тавьж, өөр өнцгөөс харж чаддаг болохыг “Нигүүлсэнгүй нүдээр хардаг болох” гэж хэлнэ.

Үүсгэн байгуулагчийн үг 9» X268-269

Living the Lotus Vol. 181 (2020.10)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Саитоо Кооичироо

Орчуулсан: Ж.Сэлэнгэ, Ж.Гэрэлтуяа

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



Сэтгэл өөрчлөгдвөл амьдрал өөрчлөгдөнө

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Бүгд адил бурханы шавь

Өмнөх сарын сэтгүүлийн дугаарт Шагжамүни бурхан ба түүний шавийн тухай яриаг танилцуулсан билээ.

Дахин сануулбал, ном цээжлэхдээ тааруугаасаа болоод бусдад гологдон, сэтгэлээр унаад байсан Кулапантака Шагжамүни бурханы үгэнд гэнэн цайлганаар итгэж, хэлснийг нь хэрэгжүүлсний ачаар “Сэтгэлээ цэвэр байлгах”-ын чухлыг ухааран, амьдрал нь орвонгоороо эргэсэн тухай гардаг.

“Сэтгэл өөрчлөгдвөл үйл хөдлөл өөрчлөгдөнө. Үйл хөдлөл өөрчлөгдвөл зуршил өөрчлөгднө. Зуршил өөрчлөгдвөл зан чанар өөрчлөгднө. Зан чанар өөрчлөгдвөл хувь тавилан өөрчлөгднө.” (Виллиам Жэймс) гэсэн хүний үндсэн мөн чанарыг тодорхой харуулсан алдарт үг бий. Энэ үг нь дээрх Кулапантакагийн түүхтэй яв цав нийцэх ба сэтгэл өөрчлөгдвөл амьдрал өөрчлөгдөж, тэр нь хувь тавилан буюу “Хувь зохиол”-ыг ч өөрчилдөг гэсэн үг юм.

Өөрөөр хэлбэл “нөхцөл” өөрчлөгдөх гэсэн үг ба Кулапантака шиг юу чухал болохыг анзаарч ухааран, сэтгэл тогтвортой болох аваас тухайн нөхцөл байдлыг хүлээж авах өнцөг өөрчлөгдөж, боломжгүй мэт зүйл байсан ч түүнийг боломжтой болгож болохыг илэрхийлсэн.

Тэгвэл бид бүхэн яадаг вэ? Ингээд асуухад л “Тэр чинь хэцүү. Би бол яасан ч чадахгүй.” гэж өөрийгөө голох хүмүүс бий байх. Гэхдээ бид ч бас Кулапантакатай адил бурханы сургаалыг сурч буй бурханы шавь нар болохоо хэзээ ч мартаж болохгүй. Бид бол эрт дээр үеийн бурханы шавь нарын адилаар аливаад сэтгэл зовон, шаналж явахдаа Бурхан багшийн сургаалтай учирч, юуг анхаарч мэдэх ёстойгоо олж ухаарсан билээ.

Аар саар хүсэл шуналд автахгүй байх, сэтгэл хөдлөлдөө автагдан уурлахгүй байх, эсвэл юмсын хувирал өөрчлөлтийг байгаагаар нь хүлээж авах гэх зэргээр тухайн хүн хийгээд нөхцөл байдлаас шалтгаалаад “Сэтгэлийн буртаг”-аа цэвэрлэх арга нь янз бүр байж болно. Ямартай ч Бурханы сургаалыг байгаагаар нь хүлээн авч, итгэж, хэрэгжүүлж явбал аяндаа хувь тавилан өөрчлөгдөх болно.



“Сүсэг бишрэл” гэдэг нь

Бурханы сургаалд итгэж хэрэгжүүлэх тухайд чухал гэдгийг нь мэдэж байгаа мөртлөө бид бүхэн заримдаа сэтгэл сатаарч, сургаалын зам мөрөөс хазайн амин хувиа бодсон үг, үйлдэл гаргадаг.

Үүний шалтгаан сургаалд “сүсэглэн бишрэх” гэсэн үгэнд байж болох юм. Үүсгэн байгуулагч “Сүсэг бишрэл гэдэг мухар сохроор итгэх гэсэн үг бус жинхэнэ үнэний хуулийг ухаарч, итгэх явдал юм.” гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл сүсэг бишрэл гэдэг зөвхөн итгээд болох бус бүх юмс хувирч өөрчлөгддөг, юу ч ганцаар оршин тогтнодоггүй гэсэн шүтэн барилдлагын сургаал болох “Жинхэнэ үнэний хууль, Бурханы Ном”-д суралцаж, түүнийхээ дагуу “Билэг билгүүн”-ээр аливаад хандаж амьдрахыг бурханы сургаалд итгэх буюу сүсэг бишрэл гэдэг.

“Бишрэх сэтгэл” гэдэг нь хүмүүс бид бурхантай адил гэдэгтээ “итгэх сэтгэл”-ыг хэлж буй юм. Тиймээс бурханд итгэх, Шагжамүни бурханд итгэх гэдэг нь хүн хүндээ итгэж, эргэн тойрныхоо хүмүүсийн бурханлаг чанарт эргэлзэлгүй итгэхтэй утга нэг юм.

Ингээд бодох юм бол сургаалд итгэж, дагаж мөрдөхийн үндэс нь одоо дэргэдээ байгаа хүндээ итгэж, хүндэтгэх явдал гэж хэлж болох бус уу.

Цагаан Лянхуа Судрын “Эрдэм буяныг ялган өгүүлэх бүлэг”-т “Бурханы насны чинээний өнө урт нь энэ мэт болохуйг сонсоод, нэгэнтээ боловч сайтар сүслэн ухахуйн сэтгэлийг төрүүлэх аваас олохуй эрдэм буян нь хэмжээ хязгаар үгүй болой.” гэсэн байдаг. Бид бурхантай цуг үүрдийн амьдралаар амьдарч байгаа, бүгд адил бурханлаг чанартай гэдэгт нэгэн агшинд ч болов итгэж, учрыг ойлгох төдийд хэмжээлшгүй их ач буяныг эдэлнэ гэсэн үг.

Бүх хүн бурхантай нэг амьтай бөгөөд бурханлаг чанарын илрэл гэдгийг орой руугаа ортол ойлгох юм бол хүмүүстэй харилцах арга, хүмүүсийн хэлснийг хүлээж авах өнцөг өөрчлөгддөг гэдгийг та бүхэн сайн мэдэж байгаа байх. Сэтгэлээ л өөрчлөөд авах юм бол үргэлж бурхантай адил уужим сэтгэлээр амар амгалан амьдрах үүд хаалга нээгдэх болно.

«Косей» 2020 оны 10 дугаар сарын дугаар



Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

«Оройн Дээд Цагаан Лянхуа Судар» Даган баясахуйн эрдэм буяныг өгүүлэх 18 дугаар бүлэг

Сургаал тавь дамжсан нь


Энэхүү бүлэгт “Анхны баясал”-ын ач буяныг илүү онцлон нарийн тодорхой өгүүлдэг. Яагаад энэ мэтчилэн дахин давтан айлдаж байна вэ хэмээвээс, сургаалыг даган баясах, өөрөөр хэлбэл зүрх сэтгэлээсээ “Сургаалтай учирсандаа талархаад баршгүй.” хэмээн бодох тэрхүү талархсан сэтгэл хийгээд баяр баясал л итгэл үнэмшлийн үгүйсгэхийн аргагүй агуу үндэс суурь, хүчин зүйл нь болдог болохоор тэр юм.

Шагжамүни бурхан “Хэрэв хэн нэгэн номын чуулганаар сургаал сонсоод, “Ямар талархмаар юм бэ.” хэмээн баяр хөөрийг мэдэрч, өөр хэн нэгэнд өөрийн чадлынхаа хирээр дөнгөж сая сонссон яриагаа ярьж өгчээ гэж бодъё. Түүнийг сонссон хүн нь ч бас адилхан баяр хөөрийг мэдэрч, мөн адил өөр хүнд дамжуулжээ гэж бодъё. Энэ мэтчилэн тавин удаа дамжихад сургаалыг сонссон тавь дахь хүн “Ямар талархмаар юм бэ.” хэмээн баярлажээ гэж үзвэл түүний ач буян нь чинээлэг нэгэн хүний бүх л амьдралынхаа туршид хийж болох бүх төрлийн өглөгийн ач буянаас хэдэн зуун сая дахин илүү үнэ цэнэтэй юм.” гэжээ. Мэдээж хамгийн анх энэхүү сургаалыг сонссон хүний хүртвэл зохих ач буян хэмээвээс үнэхээр тоо томшгүй, хэмжээ хязгааргүй юм.” хэмээн сургасан.

Хамгийн анхны хүн нь сүсэг бишрэлийн уур амьсгал бүхий номын хуралд сургаал номд гарамгай, бусдад ухуулан ойлгуулах хүчийг агуулсан номын багшийн яриаг сонссон учраас маш ихэд талархан, их буян хураах нь ойлгомжтой. Тэр нь цааш цаашид дамжсаар тавь дахь хүнд хүрэхэд ярих ур чадвар ч үгүй, сүсэг бишрэлийн уур амьсгал ч үгүй болж, сургаалын гол утга нь л үлдэж хоцорсон байх биз ээ. Тэгвэл Цагаан Лянхуа Сударт тэрхүү гол утга агуулга нь хэмжээ хязгааргүй агуу тул

тавин хүн дамжсан ч өөрийн эрхгүй сэтгэл хөдөлгөдөг.

Тэгвэл тэрхүү сэтгэл хөдлөн баярласны ач буян нь яагаад бүх л амьдралынхаа туршид өглөг өргөсөөр ирсэн баян чинээлэг нэгний хүртэх ёстой ач буянаас илүү юм бэ хэмээвээс нэгдүгээрт, сургаалыг сонсоод мэдрэх жинхэнэ аз жаргалыг юутай ч харьцуулашгүй агуу нандин үйл, хоёрдугаарт, тэрхүү баяр баясал нь цааш цаашид хүнээс хүнд дамжин хөврөх зах хязгааргүй эрч хүчийг агуулдаг учраас тэр билээ.





Сургаалтай учрах хийгээд түүнийг бусдад түгээхийн ач буян

Тэрхүү аз жаргал, баяр баяслыг мэдрээгүй ч гэсэн ном айлдах үеэр өчүүхэн төдий хугацаанд болов энэхүү Цагаан Лянхуа Судрын сургаалыг сонссоны ач буян үнэхээр их бөгөөд дараа дараачийн хүмүүст “За, энд суугаад сонсоно уу.” хэмээн хүндэтгэлтэйгээр суудалд урин залсан хүний ач буян хамгийн их болохыг сургасан.

Үүгээр сургаалтай учирна гэдэг хичнээн чухал болохыг илэрхийлж байна. Бид бүхэн бүгд адил бурханлаг чанартай болох нь маргаангүй үнэн. Гэвч бурханы номтой учрах тохиол байхгүй аваас бурханлаг чанараа олж нээж, авралд хүрэх боломжгүй. Тиймээс юун түүрүүнд сургаалтай учрах нь нэн чухал бөгөөд түүнтэй учрах шалтгаан гэдэг хичнээн нандин, чухал болохыг харж болно. Мэдээж бусдад тэрхүү сургаалтай учрах нөхцлийг бүрдүүлж өгнө гэдэг бүр л нандин үйлдэл юм.

Дүгнээд хэлбэл уг бүлэгт сургаалыг сонсоод үнэн сэтгэлээсээ талархах гэнэн цайлган сэтгэл, талархсан бол түүнийгээ бусдад түгээхгүй байж чадахгүй байх цэвэр ариун сэтгэл бол сүсэгтэн хүний хувьд хамгийн эрхэм нандин зүйл болохыг сургасан байна.





Ээжийнхээ өвчнөөр дамжуулж ухаарсан зүйл



РКК, Улаанбаатар салбар
Ариунаагийн Баярхүү

Намайг Ариунаа овогтой Баярхүү гэдэг. 2002 оны 5 сарын 24-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, 17 настай. Одоо ерөнхий боловсролын 11-р ангид суралцдаг. Ээжтэйгээ хамт амьдардаг.

Ээж маань нийгэмлэгийн гишүүн байсан учраас би жаахан байхдаа л нийгэмлэг дээрээ ирдэг байсан. Гэвч тэр үед ямар учиртайг нь сайн ойлгодоггүй, судар ном уншдаггүй нэгэн байсан. 9 настай байхдаа анх нийгэмлэгийн талаар ээжээсээ сонсож Чингис зочид буудал дээр зохион байгуулсан хурал, цуглаан дээр очиж байсан түүхтэй. Балчир байсан болохоор хурал руу ээжтэйгээ очиж, бусад гишүүдын хамтаар ном уншдаг байлаа. Тэр үед анх удаа “Цагаан лянхуа”-тайгаа учирсан юм.

Судрыг ээжтэйгээ уншиж маш тайвширч, олон сайн хүнтэй уулзалдаж, цагийг зөв өнгрөөдөг байсан. Одоо судар уншихдаа олон хүмүүстэй нэгэн зэрэг уншихад маш таатай санагддаг. Учир нь бүх хүнээс сайн энерги мэдрэгддэг, бүгд бусдад сайн сайхныг хүсэн, ном уншиж байдаг. Ном унших үеэр өөрийн эрхгүй тэрхүү сайхан орчинд уусаж амар амгалан мэдрэмж авч чаддаг юм.

Нэг өдөр хичээл рүүгээ явах замдаа гар утас, бичиг баримттай түрийвчээ хулгайд алдаж ээждээ яах хэлэх вэ гэж их айж эмээсэн. Ээж хүн хүүхэддээ хэзээ ч муу юм хийхгүй ч санааг нь зоовоохгүй гэсэндээ л айсан юмаа. Гэвч эцэст нь ээждээ хэлэхээс өөр арга байгаагүй. Ээж маань миний бурууг гэдгийг ойлгуулахын тулд намайг зэмлэсэн. Ээж мөнгөгүй байсан учраас утас авч өгч чадаагүй. Миний хувьд утасгүй болоод ээж болон найз нартайгаа холбогдох боломж байхгүй болсноос гадна өдөр өнгөрч өгөхгүй уйддаг, өөрийн эрхгүй бухимддаг болсон. Зарим үед тоглох гээд найзындаа хононо. Үүнээс болоод ээжтэйгээ маргалддаг болсон. Энэ бүхнийг сүүлд бодож

үзээд ухаарсан л даа. Ээжийгээ, ялангуяа, өвдсөн үед нь зовоох ёсгүй гэдгээ маш сайн ойлгосон.

Ээжийхээ өвдсөн тухай анх 2 сард сонсоод сэтгэлээр их унасан. Яагаад тэгж байгаа юм бол гэж бодоод гэртээ ганцаараа их уйтгартай хэцүү санагдаж гунигтай байсан. Ээжийгээ өрөвдсөн ч яах учраа олохгүй байсан. Дараа нь ээж хамаатнуудтайгаа яриад шинжилгээ өгөөд ирсэн. Би тэрийг нь хараад жаахан тайвширсан. Тэгээд ээждээ зориулж залуучуудын бүлгийн ахлагч Баясаатай хамт ном уншсан. Сэтгэл арай тайвширсан. Дараа нь төв дээрээ ирээд залуучуудтай хамт жижүүр хийж дамрын үүргийг хийж эхэлсэн бас айлд очиж ном уншиж эхэлсэн.

Мөн нэг өдөр Зоригмаа тэргүүнтэйгээ ярилцаад ээжтэйгээ яаж сайн ойлголцох талаар зөвлөгөө авсан билээ. Үүний тулд яах вэ гэж их бодож тэргүүнээсээ асуулаа. Тэгэхэд Зоригмаа тэргүүн “Ээжтэйгээ нээлттэй байгаарай, ээжийнхээ сэтгэлийг ойлгох чухал шүү” гэж



Солонгос салбар дээр илтгэл тавьж байгаа нь

зааж сургасан. Өмнө нь ээжийнхээ үгэнд төдийлөн орохгүй, өөрийнхөөрөө л зүтгэж тэр ч бүү хэл ээжийнхээ ойлгуулах гэсэн зүйлийг үл ойшоодог байлаа. Маргалдах, үг зөрөх үе зөндөө тохионо. Тэргүүнийхээ зөвлөгөөг сонссоноос хойш ээж бид хоёрын харилцаанд маш том өөрчлөлт гарсан. Ээжтэйгээ үл ойлголцох үүсэх үед тэргүүний маань хэлсэн үг бодогддог болж, ингэснээр ээжийнхээ санааг өөрийх нь өнцөгөөс ойлгох гэж хичээдэг, ээжтэйгээ илүү нээлттэй ярилцдаг болсон юм.

6 сард туслах номын сургалтанд явсан. Эхлээд дандаа настай хүмүүс байгаа гэж бодоод би явмааргүй байсан. Дараа нь яваад үзсэн чинь олон зүйл сурч, их гоё хөгжилтэй байсан. Ялангуяа Японоос ирсэн багш нарын амьдралд нь тохиолдсон яриа маш сонирхолтой санагдсан. Мөн Насад зэвүүцэхгүй бодисадвагийн бусдын бурханлаг чанарт залбирах үйл их чухал гэж сурсан. Ээжийгээ ойлгож гомдож байсандаа их харамсаж ээждээ арай илүү анхаарал тавих хүсэлтэй болсон. Ээжтэйгээ нээлттэй болж сургалтын талаар ярьсан.—Цаашид нийгэмлэг дээр ирж жижүүр хийж байхаар тохирсон. Миний хувьд 4 зорилтыг өөртөө тавьсан:

1. Судар тогтмол уншиж сурах
2. Ээжийгээ ойлгохыг хичээх, дэмжих
3. Хичээлээ шаргуу хийж сургуулиа амжилттай төгсөх
4. Зуны амралтаараа 7 хоногт 2 удаа нийгэмлэг дээр ирж, жижүүр хийх.

Мөн найзыгаа нийгэмлэг дээр дагуулж ирж гишүүнээр элсүүлэхийн төлөө хичээх болно.

8 сард Солонгос улсад болох Ришо Косэй Кай байгууллагын олон улсын залуучуудын сургалтанд оролцох төлөвлөгөөтэй байгаа. Би гадаад руу явж үзээгүй, мөн магадгүй надтай адил асуудал тулгарсан олон залуучууд очно, тэдэнтэй санал бодол хуваалцах, цаашдаа найзлах боломжийг олж хараад Зоригмаа тэргүүний саналыг дуртайяа зөвшөөрсөн. Энэ сургалтанд хэл, соёл өөр залуучууд цугларна. Маш их сэтгэл догдолж байгаа боловч бага зэрэг сандарч байна. Би Насад зэвүүцэхгүй бодисадвагийн бурханлаг чанарт мөргөх үйлийг сэтгэлдээ бодож, хүмүүсийн яриаг сайн сонсож,

ойлгохыг хичээн, бие биендээ зөв үлгэр дуурайл болж, улам их өсч хөгжихийн төлөө хичээх болно.

Анхаарал тавин сонссон та бүхэнд баярлалаа.



Сургалтанд оролцож байгаа нь

Бид бүхэн бурхантай адил нандин амь настай

10-р сар бол Үүсгэн байгуулагчийн насан өөд болсон сар билээ. Амин өдрөөр нь дамжуулан дурсан санаж, ач буянд талархаж, үйл хэргийг нь үргэлжлүүлэн сургаал түгээхээ дахин тангараглах нь зүйтэй.

Бид бүхэн Үүсгэн байгуулагчийн шавь болохоо ухамсарлаж, сургаал номыг өвлөн авч, түгээн дэлгэрүүлэх үйлсэд зүтгэх нь түүний ач буяныг хариулж буй хэрэг юм.

Ерөнхийлөгч “Сэтгэл өөрчлөгдвөл амьдрал өөрчлөгдөнө” гэсэн энэ сарын айлдвартаа сургаалд итгэж, хэрэгжүүлэх аваас хувь тавилан өөрчлөгддөг хэмээн сургасан. Үүний тулд чухал зүйл бол өөрийн болон өрөөл бусдын бурхантай адил ариун нандин бурханлаг чанарт бат итгэх явдал хэмээжээ.


Түүнчлэн дэргэдэх хүнийхээ бурханлаг чанарт итгэж, хүндлэх нь сургаалд итгэж хэрэгжүүлэхийн үндэс хэмээн сануулсан.

Корона вирусын улмаас сэтгэл санаа зовион буй хүмүүстэй гэгээлэг инээмсэглэлээр харилцаж, бага ч болов баяр баясал, амар амгаланг мэдрүүлэхийн төлөө хичээе гэж бодож байна.

РКК Олон Улсын Хэлтсийн дарга
Сайтоо Коичи



Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
 TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
 Email: sangha@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, USA
 TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
 TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
 POBox 33636, CA 90033, USA
 TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
 Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
 POBox 778, Pacifica, CA 94044, USA
 TEL: 1-650-359-6951 Email: info@rksf.org URL: <http://www.rksf.org>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

- Rissho Kosei-kai of Sacramento**
- Rissho Kosei-kai of San Jose**

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
 TEL: 1-212-867-5677 Email: rky39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
 TEL: 1-773-842-5654
 Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
 POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
 TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
 Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809 Denver, CO 80204, USA
 TEL: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
 URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
 TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-269-4567
 Email: dharmasa@rksabuddhistcenter.org
 URL: <http://rksabuddhistcenter.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
 (Mail) POBox 692148, San Antonio, TX 78249, USA
 TEL: 1-210-558-4430 FAX: 1-210-696-7745
 Email: dharmasanantonio@gmail.com
 URL: <http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
 TEL: 1-253-945-0024 Email: rkseattlewashington@gmail.com
 URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
 TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
 Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP, CEP 08730-000, Brasil

在家佛教韓國立正佼成會

〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

在家佛教韓國立正佼成會釜山支部

〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人在家佛教立正佼成會

台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會

台灣台南市崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: kosekaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001,
Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Please contact Rissho Kosei-kai of Kolkata

Rissho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,
Phnom Penh, Cambodia

RKISA Rissho Kosei-kai International of South Asia

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Bangkok

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dhamma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Please contact RiKISA

Rissho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL/FAX: 880-31-626575

Rissho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni,

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Please contact Rissho Kosei-kai Bangladesh

Rissho Kosei-kai Patiya**Rissho Kosei-kai Ramu****Rissho Kosei-kai Aburkhiln****Buddiyskiy khram "Lotos"**

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai**Rissho Kosei-kai of Ulaanbaatar**

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoro-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Please contact Rissho Kosei-kai di Rome

Rissho Kosei-kai of Paris**Rissho Kosei-kai of Venezia****Rissho Kosei-kai of the UK**

29 Ashbourne Road, London W5 3ED, UK
TEL: 44-20-8933-3247 Email: info@rkuk.org URL: <https://www.rkuk.org>
Facebook: <https://www.facebook.com/RKUnitedKingdom>
Twitter: https://twitter.com/rkuk_official
Instagram: https://www.instagram.com/rkuk_official

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.abc-rk.org>